

ЭН АР СИ СИ компани Хэрэглэгчийн итгэлийн улирал тутмын судалгааг Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвтэй хамтран 2023 оны 12-р сард амжилттай зохион байгууллаа. Судалгаанд Монгол Улсын 21 аймаг, нийслэл Улаанбаатар хотын 1103 иргэд хамрагдаж, эдийн засгийн өнөөгийн төлөв, ойрын ирээдүйн хандлагын талаар мэдээлэл өгсөн байна.


Хэрэглэгчийн итгэлийн индекс

Монгол Улсын хэрэглэгчдийн эдийн засагт итгэх итгэл 2023 оны 4-р улиралд өмнөх улирлаас 17 пунктээр буурсан байна. Бизнесийн нөхцөл болон хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдлын талаарх хэрэглэгчдийн үнэлэмжийг харуулдаг *Өнөөгийн байдлын индекс* энэ улиралд 133.6-аас 98 болж эрс буурсан, хэрэглэгч-

дийн бизнесийн нөхцөл, орлого болон хөдөлмөрийн зах зээлийн ойрын ирээдүйн хүлээлтийг харуулдаг *Ирээдүйн хүлээлтийн индекс* 96-аас 85 болж буурчээ. Хэдийгээр хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ) өмнөх улирлаас буурсан ч индексийн утга 88 байгаа нь жилийн өмнөхөөс 21.1 пунктээр өндөр үзүүлэлт юм.

Хэрэглэгчийн Итгэлийн Индекс (2018=100)

Хэрэглэгчийн итгэл 88 буюу өмнөх улирлын түвшингээс 17 пунктээр буурсан бол жилийн өмнөхөөс 21.1 пунктээр өссөн байна. Энэ улиралд өнөөгийн байдлын үнэлэмж 35.6 пунктээр, ирээдүйн хүлээлт 11 пунктээр буурсан байна.



Тайлбар: ХИИ болон түүний бүрэлдэхүүн индексүүдийг улирлын нөлөөгөөр засварлаж, 2018 оны 4-р улирлын индекстэй харьцуулж тооцсон (Индекс 2018=100).

Эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал

Хэрэглэгчдийн эдийн засгийн өнөөгийн байдлын үнэлэмж өмнөх улирлаас буурсан байна. Бизнесийн нөхцлийн талаарх үнэлэмж буурсан. 6.4 хувь нь бизнесийн нөхцөл “сайн” гэж хариулсан нь 4.7 пунктээр доогуур байна. 56.5 хувь нь бизнесийн нөхцөл “муу” гэж хариулсан бөгөөд энэ нь 17.2 пунктээр өндөр байна. Хэрэглэгчдийн хөдөлмөрийн зах зээлийн үнэлгээ ч мөн буурсан. 27.6 хувь нь ажлын олдоц “элбэг” гэж хариулсан нь өмнөх улирлаас 5.9 пунктээр доогуур, 35.4 хувь нь ажил олоход “хэцүү” гэж хариулсан нь өмнөх улирлаас 4.0 пунктээр өндөр байна.

Эдийн засгийн ойрын ирээдүйн төлөв Хэрэглэгчдийн эдийн засгийн ойрын ирээдүйн талаарх хүлээлт буурсан байна. Ялангуяа хэрэглэгчид ойрын ирээдүйд бизнесийн нөхцөл буурна гэж үзжээ. Хэрэглэгчдийн 11.4 хувь нь ойрын ирээдүйд бизнесийн нөхцөл “сайн” байна гэж хариулсан нь өмнөх улирлаас 3.3 пунктээр доогуур, 28.1 хувь нь бизнесийн нөхцөл “муу” байна хариулсан нь өмнөх улирлаас 9.4 пунктээр өндөр байна. Харин ажил эрхлэлт болон орлогын хувьд нөхцөл байдал тодорхойгүй байна. Хэрэглэгчдийн 20.1 хувь нь орлого өснө гэж үзсэн нь 7.0 пунктээр доогуур байгаа бол, 14.2 хувь нь орлого буурна гэж үзсэн нь 2.8 пунктээр доогуур байна. Мөн 20.5 хувь нь ажлын олдоц сайжирна гэж үзсэн нь 2.1 пунктээр доогуур байгаа бол 15.9 хувь нь муудна гэж үзсэн нь 1.3 пунктээр доогуур байна.

ХИИ-д нөлөөлж буй хүчин зүйлс

	2022.IV	2023.III	2023.IV	Жилийн өөрчлөлт	Улирлын өөрчлөлт
Өнөөгийн байдал					
<i>Бизнесийн нөхцөл</i>					
Сайн	2.7	11.1	6.4	3.7	-4.7
Хэвийн	26.9	45.3	36.2		
Муу	69.7	39.3	56.5	-13.2	17.2
<i>Ажлын олдоц</i>					
Сайн	22.7	33.5	27.6	4.9	-5.9
Хэвийн	34.3	31.6	35.4		
Муу	41.7	31.4	35.4	-6.3	4.0
Ойрын ирээдүй					
<i>Бизнесийн нөхцөл</i>					
Сайн	11.7	14.7	11.4	-0.3	-3.3
Хэвийн	45.8	61.0	58.2		
Муу	37.5	18.7	28.1	-9.4	9.4
<i>Ажлын олдоц</i>					
Сайн	19.4	22.6	20.5	1.1	-2.1
Хэвийн	55.5	55.8	60.4		
Муу	22.2	17.2	15.9	-6.3	-1.3
<i>Орлого</i>					
Сайн	14.7	27.1	20.1	5.4	-7.0
Хэвийн	62.6	53.5	63.9		
Муу	21.2	17.0	14.2	-7.0	-2.8


Хэрэглэгчийн итгэл ба эдийн засгийн өсөлт

Хэрэглэгчийн итгэлийн индексийг олон улс орнууд үнэлж мэдээлдэг бөгөөд тухайн орны эдийн засгийн төлөв байдлыг сайн харуулж чаддаг гэж үздэг. Монгол Улсад ч ХИИ-ийг улирлаар үнэлж эхэлснээс хойшхи динамикийг харвал эдийн засгийн өсөлттэй ойрхон хамаа-

ралтай байна. ХИИ-ийн индекс хэвийн буюу 100 ба түүнээс дээш утгатай улирлуудад эдийн засаг дунджаар 6.1 хувийн өсөлттэй байсан бол ХИИ 100-гаас бага утгатай улирлуудад эдийн засаг 2.6 хувийн өсөлттэй байна.

Хэрэглэгчийн итгэл ба эдийн засгийн өсөлт

Хэрэглэгчийн итгэлийн индекс эдийн засгийн өсөлттэй ойрхон хамааралтай байна



Эх үүсвэр: ҮСХ-ны 1212.mn мэдээллийн сайт. Тайлбар: Эдийн засгийн өсөлтийн мэдээллийг ҮСХ-ны цахим хуудаснаас авсан.



2023 оны 4-р улиралд хэрэглэгчдийн эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлын үнэлэмж буурахад бизнесийн нөхцөл болон ажлын олдоц буурсан нөлөөлжээ. Ойрын ирээдүйд бизнесийн нөхцөл муудна гэсэн хүлээлт байгаа ч ажлын олдоц болон орлого тодорхойгүй байна.

Инфляцын хүлээлт

Ирэх нэг жилийн хугацаанд үнийн түвшин өснө гэсэн хүлээлттэй иргэдийн хувь 82 байна. Хэрэглэгчид инфляцын түвшинг ирэх нэг жилийн хугацаанд 13 хувь байна гэсэн хүлээлттэй байна. Хүлээгдэж буй инфляцын түвшинг өмнөх жилийн болон улирлын үзүүлэлттэй харьцуулахад 5 болон 3.9 пунктээр их байна.


Эндээс үзвэл иргэдийн дийлэнх хувь нь үнийн түвшин өснө гэж үзэж байгаа ба хүлээгдэж буй инфляцын түвшин өсөж байна. Энэ улиралд инфляцын талаарх тодорхой бус байдал буурсан. Өмнөх улиралд 26 хувь нь

ирэх нэг жилийн хугацаанд инфляцын өөрчлөлтийг мэдэхгүй гэж хариулсан бол энэ улиралд 7 болж буужээ.

Хөдөө амьдардаг хэрэглэгчдийн ирэх нэг жилийн хугацааны үнийн түвшний хүлээлт Улаанбаатар хотод амьдардаг хэрэглэгчдээс өндөр байна. Хөдөө жилийн хүлээгдэж буй инфляц 13.1 хувь байгаа бол хотод 12.4 хувь байна. Өмнөх улиралтай харьцуулахад хөдөө болон хотод амьдардаг хэрэглэгчдийн инфляцын хүлээлтийн зөрүү бага байна.

Үнийн хүлээлт, ирэх нэг жилийн хугацаанд

Ирэх нэг жилийн хугацааны инфляцын хүлээлт 13% (Хөдөө-13.1%, Хот-12.4%) байгаа нь өмнөх оны мөн үеэс 5 пунктээр их байна.



Эх сурвалж: ҮСХ-ны 1212.mn мэдээллийн сайт

